

УВС АЙМГИЙН 2017 ОНЫ 05 ДУГААР САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2017.06.05

Улаангом сум

Нэг. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн цагдаагийн газарт 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 295, зөрчлийн шинжтэй 775, бусад-129 нийт-1244 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс -123 нэгжээр буюу -8.9 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад -48 нэгжээр буюу -13.9 хувиар буурсан байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 156 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 139 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай Прокурорын хяналтанд хүргүүлж шийдвэрлэсэн. Захиргааны зөрчлийн шинжтэй 775 гомдол мэдээлэл хүлээн авснаас 523 буюу 67.4 хувийг шийтгэврийн хуудсаар, 56 буюу 7.2 хувийг торгуулийн хуудсаар торгож, 79 буюу 10.1 хувийг баривчлах, 112 буюу 14.4 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч торгох шийтгэл ноогдуулан шийдвэрлэсэн.

Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 355 хүнийг саатуулсан нь +62 нэгжээр өссөн байна.

ЗХАБТХ, ГБХТТХ-иар Увс аймгийн сум дундын шүүхээр 79 иргэнийг 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс 59 нэгжээр буюу +295 хувиар өссөн.

Торгуулийн хуудсаар, бэлэн бус торгуулиар 3683 зөрчилд 89.444.000 төгрөгний торгууль, шийтгэврийн хуудсаар 740 зөрчилд 78.930.000 төгрөгний торгууль ногдуулсан.

Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд 142 гэмт хэрэг бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс +20 хэргээр буюу +16.4 хувиар өссөн байна.

- Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 84.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс +9.4 хувиар өссөн.

Хэргийг ангиллаар нь авч үзвэл: хөнгөн гэмт хэрэг-96, хүндэвтэр гэмт хэрэг-41, хүнд-5, онц хүнд гэмт хэрэг бүртгэгдээгүй.



2017 оны эхний 04 сарын байдлаар 96 буюу 67.6 хувьд нь хэрэг бүртгэлт, 46 буюу 32.3 хувьд нь мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Хялбаршуулсан журмаар 68 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 хэргээр буюу 119.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

-78 хэрэг буюу 54.9 хувь нь бусад суманд

-64 хэрэг буюу 45.1 хувь нь Улаангом сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн

Гарсан гаригаар нь авч үзвэл:

-Даваа-20

-Мягмар-21

-Лхагва-21

-Пүрэв-25

-Баасан-22

-Бямба-16

-Ням-17

Гэмт хэргийг гарсан цагаар нь авч үзвэл:

-06-14 цагт -23

-14-19 цагт-33

-19-22 цагт-34

-22-06 цагт-52 тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас :

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад учирсан 186.000.000 төгрөгний хохиролын 158.200.000 төгрөгний хохиролыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь нь 85.0 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад +4.0 хувиар өссөн. Иргэд аж ахуй нэгж байгууллагаас 209.000.000 төгрөгний хохирол битүүмжилж ажилласан.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

-Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг -4

-Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг-61

-Танхайрах гэмт хэрэг-2

-Хүчиндэх-3

-Иргэдийн өмчийн хулгай-19

-Малын хулгай -26

-Тээврийн хэрэгслийн хулгай-1

-Залилан мэхлэх-1

-Завших, үрэгдүүлэх-1

-ТХХАБЖЭГХ / 215 / -4

-БХЖЭГХ-1

-Гээгдэл эд зүйл, мал ашиглах-11

-Бусдын эд хөрөнгө санаатай устгаж гэмтээх гэмт хэрэг-1 тус тус бүртгэгдсэн байна.

Үйлдэгдсэн бүх хэргийн 46 буюу 32.3 хувь нь хулгайн хэрэг, хулгайн хэргийн 26 буюу 56.5 хувийг мал хулгайлах хэрэг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад +16 хэргээр буюу +160 хувиар өссөн. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 19 байгаа нь өмнөх оноос -1 хэргээр буюу -5.0 хувь буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг +16 нэгжээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг +3 нэгжээр, гэр орон сууц +10 нэгжээр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг +8 нэгжээр тус тус өсч бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг-7, эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг -6 нэгжээр тус тус буурч, хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

М.ОДХҮҮ